



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/209

Мандалговь

Мөнх консалтинг ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “2, 3-р өргөх насос станцын дунд хийгдсэн байгаа 3.5км дан цэвэр усны шугамыг хос шугам болгох ажлын зураг, төсөв /225мм диаметртэй РЕ хуванцар хоолой/”-н зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Мөнх консалтинг” ХХК-тай 25,498,000 (хорин таван сая дөрвөн зуун ерэн найм мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан ажлын даалгаврын дагуу 2, 3-р өргөх насос станцын дунд хийгдсэн байгаа 3.5км дан цэвэр усны шугамыг хос шугам болгох ажлын зураг, төсөв /225мм диаметртэй РЕ хуванцар хоолой/”-н зураг төсөв боловсруулах ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мөнх консалтинг” ХХК-ийн захирал (Д.Цэрэнбал)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л. ДОРЖБАТ



4088150507